

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/298/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/133

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант онд 3,347.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

019020257

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	142,706,677.65	102,101,360.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	113,558,579.25	71,310,706.90
312	Банканд байгаа бэлэн мөнгө	113,558,579.25	71,310,706.90
3121	Төгрөг	113,558,579.25	71,310,706.90
31211	Төрийн сангийн харилцах	113,558,579.25	71,310,706.90
35	БАРАА МАТЕРИАЛ	29,148,098.40	30,790,653.40
354	Хангамжийн материал	29,148,098.40	30,790,653.40
35410	Бичиг хэргийн материал	690,980.00	1,413,280.00
35420	Аж ахуйн материал	22,501,883.40	25,893,603.40
35460	Хүнсний материал	4,016,235.00	1,544,770.00
35470	Бусад хангамжийн материал	1,939,000.00	1,939,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	760,050,729.28	746,769,164.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	760,050,729.28	746,769,164.79
392	Биет хөрөнгө	758,050,729.28	744,769,164.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	835,357,943.00	835,357,943.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(97,452,461.28)	(111,375,093.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,890,587.00	31,238,507.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,431,866.14)	(19,488,729.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,446,480.00	13,065,560.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,288,956.30)	(10,843,025.04)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,630,430.00	13,915,430.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,213,430.00)	(8,213,430.00)
39217	Ном	1,112,003.00	1,112,003.00
393	Биет бус хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
39301	Программ хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	902,757,406.93	848,870,525.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	902,757,406.93	848,870,525.09
51	Засгийн газрын хувь оролцоо	902,757,406.93	848,870,525.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	141,182,288.00	141,182,288.00
51101	Өмч: - төрийн	141,182,288.00	141,182,288.00
512	Хуримтлагдсан үр дүн	761,575,118.93	707,688,237.09
51210	Өмнөх үеийн үр дүн	761,575,118.93	761,575,118.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(53,886,881.84)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	902,757,406.93	848,870,525.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	314,296,971.00	194,945,820.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,927,171.00	3,347,920.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,364,271.00	3,347,920.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,364,271.00	3,347,920.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,364,271.00	3,347,920.00
122	Тусламжийн орлого	26,562,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,056,600.00	30,535,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277,313,200.00	161,062,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,056,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,056,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	30,535,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	30,535,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	207,463,212.54	248,635,090.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	207,463,212.54	248,635,090.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,600,330.54	246,771,358.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,653,359.62	147,520,561.74
210101	Үндсэн цалин	91,746,113.07	117,681,852.24
210102	Нэмэгдэл	15,631,188.88	24,436,299.12
210104	Урамшуулал	6,276,057.67	5,402,410.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,167,884.13	17,153,920.61
210201	Тэтгэврийн даатгал	12,553,042.45	12,032,459.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,035,139.98	1,405,484.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,042,932.10	1,069,611.01
210204	Ажилгүйдлийн даатгал	227,800.66	235,448.90
210205	Эрүүл мэндийн даатгал	2,308,968.94	2,410,917.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,343,438.00	27,710,298.57
210301	Гэрэл, цахилгаан	2,534,297.00	3,062,663.07
210302	Түлш, халаалт	22,359,141.00	24,170,035.50
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	477,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,771,400.00	5,324,740.00
210401	Бичиг хэрэг	1,455,950.00	556,550.00
210402	Тээвэр, шатахуун	1,260,600.00	2,825,590.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,054,850.00	1,942,600.00
2105	Нормативт зардал	20,694,242.20	28,417,965.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,000.00	00.00
210502	Хоол, хүнс	19,766,572.20	28,417,965.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	910,670.00	00.00

Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	00.00
210604	Урсгал засвар	500,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	887,000.00	525,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	887,000.00	525,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,583,006.59	20,118,872.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	973,000.00	2,467,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	338,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,272,006.59	17,651,872.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,862,882.00	1,682,531.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,953,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,953,100.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	909,782.00	1,682,531.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	909,782.00	1,682,531.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	106,833,758.46	(53,689,270.15)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	197,611.69
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	197,611.69
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	(197,611.69)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	106,833,758.46	(53,689,270.15)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	308,932,700.00	191,597,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,562,900.00	00.00
122	Тусламжийн орлого	26,562,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	282,369,800.00	191,597,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	277,313,200.00	161,062,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,056,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,056,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	30,535,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	30,535,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	195,374,120.75	232,625,772.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	195,374,120.75	232,625,772.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189,511,238.75	230,943,240.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	113,653,359.62	147,520,561.74
210101	Үндсэн цалин	91,746,113.07	117,681,852.24
210102	Нэмэгдэл	15,631,188.88	24,436,299.12
210104	Урамшуулал	6,276,057.67	5,402,410.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,167,884.13	17,153,920.61
210201	Тэтгэврийн даатгал	12,553,042.45	12,032,459.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,035,139.98	1,405,484.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,042,932.10	1,069,611.01
210204	Ажилгүйдлийн даатгал	227,800.66	235,448.90
210205	Эрүүл мэндийн даатгал	2,308,968.94	2,410,917.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,153,118.00	28,352,448.57
210301	Гэрэл, цахилгаан	2,534,297.00	3,062,663.07
210302	Түлш, халаалт	21,499,241.00	24,170,035.50
210303	Цэвэр, бохир ус	1,119,580.00	1,119,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	00.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	00.00
2105	Нормативт зардал	21,422,557.00	25,283,390.00
210502	Хоол, хүнс	21,422,557.00	25,283,390.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	887,000.00	550,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	887,000.00	550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,623,820.00	12,802,920.00

Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,374,370.00	11,137,520.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,249,450.00	1,665,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,862,882.00	1,682,531.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,953,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,953,100.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	909,782.00	1,682,531.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	909,782.00	1,682,531.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	113,558,579.25	(41,027872.35)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,220,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,220,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,220,000.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	00.00	1,220,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	(1,220,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	113,558,579.25	(42,247,872.35)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	113,558,579.25
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	113,558,579.25	71,310,706.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,182,288.00	654,741,360.47	795,923,648.47
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	141,182,288.00	654,741,360.47	795,923,648.47
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	106,833,758.46	106,833,758.46
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,182,288.00	761,575,118.93	902,757,406.93
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,182,288.00	761,575,118.93	902,757,406.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	141,182,288.00	761,575,118.93	902,757,406.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	(53,886,881.84)	(53,886,881.84)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	141,182,288.00	707,688,237.09	848,870,525.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		113,558,579.25	(113,558,579.25)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	305,156,400.00	232,163,220.92	72,993,159.08	76.1%
УРСГАЛ ЗАРДАЛ	305,156,400.00	232,163,220.92	72,993,159.08	76.1%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	305,156,400.00	232,163,220.92	72,993,159.08	76.1%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,376,500.00	147,520,561.74	54,885,938.26	72.9%
Үндсэн цалин	143,683,800.00	117,681,852.24	26001947.76	81.9%
Нэмэгдэл	55,003,600.00	24,436,299.12	30,567,300.88	44.4%
Урамшуулал	3,689,100.00	5,402,410.38	(1,713,310.38)	146.4%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	25,296,100.00	17,153,920.61	8,142,179.39	67.8%
Тэтгэврийн даатгал	17,201,500.00	12,032,459.56	5,169,040.44	70.0%
Тэтгэмжийн даатгал	2,023,700.00	1,405,484.09	618,215.91	69.5%
ҮОМШӨ-ний даатгал	1,618,700.00	1,069,611.01	549,088.99	66.1%
Ажилгүйдлийн даатгал	404,600.00	235,448.90	169,151.10	58.2%
Эрүүл мэндийн даатгал	4,047,600.00	2,410,917.05	1,636,682.95	59.6%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,035,000.00	28,352,448.57	1,682,551.43	94.4%
Гэрэл, цахилгаан	4,230,700.00	3,062,663.07	1,168,036.93	72.4%
Түлш, халаалт	24,684,300.00	24,170,035.50	514,264.50	97.9%
Цэвэр, бохир ус	1,120,000.00	1,119,750.00	250.00	100.0%
Норматив зардал	33,953,800.00	25,946,500.00	8,007,300.00	76.4%
Хоол, хүнс	33,953,800.00	25,946,500.00	8,007,300.00	76.4%
Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00		100.0%
Урсгал засвар	500,000.00	500,000.00		100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	555,200.00	550,000.00	5,200.00	99.1%
Мэдээллийн технологийн зардал	555,200.00	550,000.00	5,200.00	99.1%
Бараа үйлчилгээний бусад зардал	12,439,800.00	12,139,810.00	299,990.00	97.6%
Бараа үйлчилгээний бусад зардал	10,774,200.00	10,474,410.00	299,790.00	97.2%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,665,600.00	1,665,400.00	200.00	100.0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	191,597,900.00	191,597,900.00		100.0%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	161,062,900.00	161,062,900.00		100.0%
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	161,062,900.00	161,062,900.00		100.0%

Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,535,000.00	30,535,000.00		100.0%
Орон нутгийн төсвөөс	30,535,000.00	30,535,000.00		100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		113,558,579.25	(113,558,579.25)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		71,310,706.90	(71,310,706.90)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	10	10		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	5	5		
Үйлчлэх ажилтан	4	4		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйл ажиллагааг танхимын болон зайны сургалтын хэлбэрийг хослуулан, үе шаттайгаар чанартай зохион байгуулж, эцэг эх асран хамгаалагчийн дэмжлэг оролцоог бүхий л хэлбэрээр дэмжин, суралцахууд тулгарч буй бэрхшээлийг арилгах замаар хүүхэд бүрийг ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН болгон төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна. Тус байгууллага нь анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилт, хэрэгжүүлэх 53 арга хэмжээтэй баталснаас нийт 86.7 %-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх

нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,886.9 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	113,558.6	71,310.7	(42,247.9)
Бараа материал	29,148.1	30,790.6	1,642.5
Үндсэн хөрөнгө	760,050.7	746,769.2	13,281.5)
Нийт хөрөнгө	902,757.4	848,870.5	(53,886.9)
Засгийн газрын хувь оролцоо	902,757.4	848,870.5	(53,886.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	902,757.4	848,870.5	(53,886.9)

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 42,247.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн зарцуулалттай холбоотой.

Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 6,427.3 мянган төгрөг, аж ахуйн материал 4,812.4 мянган төгрөг, түлш шатахуун 3,303.2 мянган төгрөг, барилгын материал 500.0 мянган төгрөг, хүнсний материал 22,818.8 мянган төгрөг, нийт 32,918.4 мянган төгрөгийн бараа материал тус бүр худалдан авснаар нэмэгдэж, тайлант хугацаанд 31,273.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 935.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан, 285.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг авч, 3,347.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авснаар үндсэн хөрөнгө данс нэмэгдэж байгуулсан элэгдлийн дүнгээр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 848,870.5 мянган төгрөг болж 53,886.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 229,063.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,535.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 45,558.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 305,155.6 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 305,156.4 мянган төгрөгөөс 2 удаа тодотгол хийж 191,597.9 мянган төгрөгийн санхүүжилт, өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 113,558.6 мянган төгрөг, нийт 305,156.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 305,156.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулаагүй үлдэгдэл 1,682.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 232,163.2 мянган төгрөг буюу 76.1 хувьтай байна.

Хүснэгт 2.

/мянган төгрөг/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71801- Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,372.8	1,085.0	287.8	79.3%
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	32,468.8	25,138.8	7,130.0	77.3%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,677.6	2,668.4	9,200.0	77%
1.4	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	882.6	880.7	1.9	99.9%
1.5	Нүүдлийн бүлэгт хамруулах	10,664.9	4,850.7	5,814.2	45%
1.6	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	184,365.1	135,347.4	49,018.0	73%
1.7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	42,188.8	33,339.7	8,849.1	79.1%
1.8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	30,535.0	28,852.5	1,682.5	94%
	Дүн	305,155.6	232,163.2	82,183.1	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэглэг нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 46,393.6 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоол хүнс 33,953.8 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 12,439.8 төгрөгийн бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, бараа үйлчилгээний бусад зардлуудыг шууд худалдан авалтаар худалдан авахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 36,865.7 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хийсэн байна. Худалдан авалтын дүн буурсан нь хүүхдийн тоо буурсантай холбоотой.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 207,463.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,111.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,333.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

Судалгааны үр дүн, нөхцөл байдлын талаар бичих

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг бүртгэлд байгаа үндсэн хөрөнгө болон цалин хөлс, урамшуулал, байр ашиглалт, эрүүл мэндийг дэмжих, хүүхдийн хоол, багшийн мэргэжил дээшлүүлэх, цахим хэрэглээ, хэрэгжиж буй төсөл арга хэмжээтэй холбоотой 8 судалгааг ирүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 171 мэдээллээс 19 мэдээллийг хугацаа хоцроож, 151 мэдээллийг хуулийн хугацаанд, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 2 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 15 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	3,134.9	2	3,134.9	100%
Зөвлөмж	3	26,415.6	3	26,415.6	100%
Нийт дүн	5	29,550.5	5	29,550.5	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 113,756.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн акталсан хөрөнгийн элэгдлийн дүн 197.6 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгагдаагүй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн улсын төсвийн орлогыг 113,558.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар 357.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 1 төлбөрийн акт тогтоож, 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Ажилтан, албан хаагчдын цалингаас даатгуулагчийн НДШ-ийг 30.9 мянган төгрөгөөр дутуу тооцож суутган тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх” зарчмыг хэрэгжүүлэн ажиллах” гэж заасантай нийцэхгүй, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн 30.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

5.2 Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” г гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэхийг хориглосон 326.4 мянган төгрөгийн хоол, хүнсний бүтээгдэхүүн авч хэрэглэсэн байна. Энэ нь УСНББОУС-ын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал 5.20-д “Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүснэ”, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн хамтарсан А/448, А/268 дугаартай “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай” тушаалд заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж хориглосон хоол хүнсийг хэрэглэхгүй байх хэвших

2. Хандив тусламжийн орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд эцэг, эхчүүд болон иргэд, байгууллагаас авсан хандив тусламжийн үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа “Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан”-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1-д “Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль /цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг “Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан”-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах харилцааг энэхүү дүрмээр зохицуулна” гэж заасантай, санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох заавар журмын дагуу тайлант хугацаанд хандив тусламжийн үндсэн хөрөнгө, бараа материалыг сан бүрдүүлэн орлогод бүртгэж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайланд акталсан хөрөнгийн элэгдлийг тусгаагүй	1	197.6			1	197.6	1	197.6				
Улсын төсвийн орлогыг дутуу тайлагнасан	1	113,558.5			1	113,558.5	1	113,558.5				
Дүн	2	113,756.1			2	113,756.1	2	113,756.1				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажиллагсдын цалингаас НДШ-ийг дутуу суутгасан	1	30.9	1	30.9								
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй.	1	-							1	-		
Хориглосон хоол хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсэн.	1	326.4					1	326.4				
Хандив тусламжийн орлогыг сургууль, цэцэрлэг хөгжүүлэх санд бүртгээгүй.	1	-					1	-				
Дүн	4	357.3	1	30.9	1	-	2	326.4	1	-		



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 67-17225502-ТӨА-2024/298/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ажилтан, албан хаагчдын цалингаас даатгуулагчийн НДШ-ийг 30,953.73 төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан байна.

Энэ нь "Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12-т "Энэ хуулийн 7.4.3-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын зохих санд ажил олгогч сар бүр төлнө" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодогч Т.Хишигсүрэнгээр 30,953.73 /Гучин мянга есөн зуун тавин гурван төгрөг далан гурван мөнгө/ төгрөгийг төлүүлэн Төв аймгийн Төрийн сан дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Б.Янжмаа, нягтлан бодогч Т.Хишигсүрэн нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019050226



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 120-17225502-ТӨА-2024/298/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг, Санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж тайлагнах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Б.Янжмаад даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ